



“ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ 2016” СУДАЛГААНЫ ТАЙЛАН



**Тайлан боловсруулсан:
Улаанбаатар Аудит Корпораци ХХК**

АГУУЛГА

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны баг	3
Товчилсон үгийн тайлбар	3
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
БҮЛЭГ 1. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ	5
зохион байгуулалт, аргазүй	5
1.1 Судалгааны зорилго	5
1.2 Судалгааны бэлтгэл ажил	5
1.3 Судалгааны хамрах хүрээ	5
1.4 Судалгааны түүвэрлэлт	5
1.5 Судалгааны зохион байгуулалт	6
1.6 Мэдээлэл цуглуулалт	6
1.7 Мэдээлэл боловсруулалт	6
1.8 Судалгааны явцад гарсан хүндрэл бэрхшээл	7
БҮЛЭГ 2. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ	7
2.1 Судалгаанд хамрагдагчдын ерөнхий мэдээлэл	7
2.2 Судалгааны үндсэн мэдээлэл	8
БҮЛЭГ 3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ	13
3.1 Судалгаанд хамрагдагчдын ерөнхий мэдээлэл	13
3.2 Газар тариалангийн салбарын бодлого	14
3.3 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр	15
3.4 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	17
3.5 Үндэсний төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт	17
3.6 Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт	19
БҮЛЭГ 4. ХҮНСНИЙ САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ	19
4.1 Судалгаанд хамрагдагчдын ерөнхий мэдээлэл	19
4.2 Хүнсний салбарын бодлого	20
4.3 Үндэсний төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт	21
БҮЛЭГ 5. ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ	22
5.1 Хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн ерөнхий мэдээлэл	22
5.2 Хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого	23
5.3 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр	24
5.4 Үндэсний төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт	27
БҮЛЭГ 6. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН	31
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ	31
6.1 Мал аж ахуйн салбар:	31
6.2 Газар тариалангийн салбар:	31
6.3 Хүнсний салбар:	31
6.4 Хөнгөн үйлдвэрийн салбар:	31
БҮЛЭГ 7. “ХХААХҮ-ИЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ 2016” СУДАЛГААНЫ	55
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	55

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ БАГ**Багийн ахлагч:**

Б.Осоргарав “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн ерөнхий захирал

Багийн зөвлөх:

А.Энхтүвшин “Стандарт шийдэл мониторингийн төв” ТББ-ын захирал, “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн Ахлах зөвлөх
 Э.Тунгалаг “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн статистикч, зөвлөх, бодлогын дүн шинжилгээний магистр

Багийн менежер:

Л.Цэвэлмаа “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн Партнер, магистр

Багийн судалгааны ахлах ажилтан:

Р.Бүрнээ “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн социологич-судлаач

Багийн гишүүд:

Г.Энхцэцэг “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн судлаач, магистрант, багийн гишүүн

О.Лхамсүрэн “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн судлаач, багийн гишүүн

Ц.Нямнамжил “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн судлаач, багийн гишүүн

Б.Саранзаяа “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн судлаач, багийн гишүүн

А.Ганчимэг “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн судлаач, багийн гишүүн

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

CSProCensus and Survey Program

БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
МАА	Мал аж ахуй
ТМД	Тусгай мэргэжлийн дунд
УИХ	Улсын их хурал
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах Герман улс
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААЯ	Хүнс хөдөө аж ахуйн яам
МХАҮТ	Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг баталж захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг тодорхойлсон.

Уг тогтоолын 8 дугаар зүйлийн 58-д “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгээр дамжин хэрэгжиж байгаа төрийн бодлого иргэдийн амьдралд ямар үр нөлөө үзүүлснийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт болон Хэрэглэгчийн үнэлгээгээр үнэлнэ”, 59-д “Хэрэглэгчийн үнэлгээг төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн 3-5 хүртэлх хувийг эсхүл аж ахуйн нэгжүүдийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргах бөгөөд уг үнэлгээг шууд хэрэглэнэ” түүнчлэн 60-д “Хэрэглэгчийн үнэлгээг судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулж хийлгэнэ. Тэдгээр байгууллагыг сонгох ажиллагааг тухайн үнэлгээ хийлгэх байгууллага зохион байгуулна” гэж заасны дагуу яамдаас хэрэгжүүлсэн зорилтуудын биелэлтийн талаар хэрэглэгчдийн үнэлгээг жил бүр хийж байхаар тусгасан.

Дээрх тогтоолын дагуу ХХААХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захиалгаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх зорилгоор хэрэглэгчийн үнэлгээний судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны ажлыг 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр ХХААХҮЯ-тай байгуулсан 20170214/09-022 тоот гэрээг үндэслэн дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1.	Судалгааны бэлтгэл ажил	2017.01.27-ноос 2017.02.12
2.	Судалгаа зохион байгуулах	2017.02.15-наас 2017.03.01
3.	Мэдээлэлд дүн шинжилгээ хийх	2017.03.01-нээс 2017.03.07
4.	Тайлан боловсруулж, хүргүүлэх	2017.03.07-ноос 2017.03.15

БҮЛЭГ 1. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГАЗҮЙ

1.1 Судалгааны зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хэрэглэгчийн үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулахад судалгааны зорилго оршино.

1.2 Судалгааны бэлтгэл ажил

Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүд, үндэсний хөтөлбөр болон олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй танилцан баримт бичгийн судалгаа хийлээ.

Баримт бичгийн судалгаанд Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан мал аж ахуй(МАА), газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг хангахад чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийг судаллаа.

Түүнчлэн олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Ногоон алт" бэлчээрийн экосистемийн удирдлага хөтөлбөрийн II үе шат, "Малын эрүүл мэнд", Хөдөө аж ахуйн маркетинг төсөл Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, "Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргааг бүрдүүлэх" төслүүд, газар тариалангийн салбарт хэрэгжүүлж буй "Монгол Улс дахь Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил", "Буудайн элит үр гаргах, үр үржүүлэх" хөтөлбөрүүд болон салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй олон улсын байгууллагын бусад төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг судаллаа.

1.3 Судалгааны хамрах хүрээ

Хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Архангай, Орхон, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийг хамрууллаа.

1.4 Судалгааны түүвэрлэлт

Судалгааны зорилгод нийцсэн түүврийн хүрээ нь сонгогдсон аймаг, дүүргийн насанд хүрсэн нийт хүн ам буюу салбарын хэрэглэгчид юм. Түүврийн эх олонлогоор сонгогдсон аймаг, дүүргийн 2015 оны насанд хүрсэн суурин хүн амын тоог авсан.

Хүснэгт 1.4.1

Суурин хүн амын тоо, 2015 он

Аймаг, нийслэл	Нийт хүн амын тоо	Насанд хүрсэнхүн амын тоо (18 ба түүнээс дээш насны)
Архангай	91,760	58,849
Орхон	98,750	66,237
Сэлэнгэ	104,725	68,973
Улаанбаатар:		
Баянзүрх	320,852	213,181
Сонгинохайрхан	307,224	202,068
Хан-Уул	150,946	98,030
Нийт	1,074,257	707,338

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн хороо

Судалгааны түүврийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонголоо. Энгийн санамсаргүй түүвэр буюу нийт эх олонлогоос судалгаанд хамруулах өрх бүрийг тэнцүү магадлалтайгаар сонгох тохиолдолд түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцно.

$$n = \frac{t^2 p(1-p)N}{Ne^2 + t^2 p(1-p)}$$

Энд,

n – түүврийн хэмжээ

t – итгэх түвшний утга

p – нийт хүн амд эзлэх насанд хүрсэн хүн амын хувь

N – эх олонлогийн хэмжээ / насанд хүрсэн хүн амын тоо

e – түүврийн алдааны хязгаар

Түүврийн алдааны хязгаарыг 2.5 хувь, итгэх магадлалыг 95 хувь байхаар тооцвол түүврийн оновчтой хэмжээ 1380 байна. Эндээс загварын нөлөөг 1.4-1.5 байхаар тооцож үзвэл (түүвэр судалгааны практикаас харахад загварын нөлөөний коэффициент хамгийн багадаа 1.2 байдаг) нийт 1932-2070 иргэдийг судалгаанд хамруулах нь оновчтой байлаа.

Дээрх аргачлалын дагуу түүврийн хэмжээг тогтоож энэ удаагийн хэрэглэгчийн судалгаанд Архангай, Орхон, Сэлэнгэаймаг, Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-уул дүүргийн нийт 2059 хэрэглэгчтэй биечлэн уулзаж санал авсан бөгөөд үүний 23% нь мал аж ахуйн, 14% нь газар тариалангийн, 33% нь хүнсний, 30% нь хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчид тус тус байлаа.

1.5 Судалгааны зохион байгуулалт

Судалгааны асуулгын хуудас

ХХААХҮЯ-ны үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хамрагдаж буй дөрвөн салбар буюу мал аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэрийн салбар тус бүрээр судалгааны асуулга боловсруулсан. Судалгааны агуулгын хураангуйг дараах хүснэгтэд үзүүлэв. Үүнд:

Хүснэгт 1.5.1

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны асуулгын агуулга

д/д	Салбар	Асуулгын бүлгийн тоо	Асуулгын тоо	Агуулга
1.	МАА	4	31	Асуулгад хамрагдагчдын талаарх ерөнхий мэдээлэл, МАА-н салбарын бодлого, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, олон улсын төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт
2.	Газар, тариалан	4	27	Асуулгад хамрагдагчдын талаарх ерөнхий мэдээлэл, газар тариалангийн салбарын бодлого, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, олон улсын төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт
3.	Хүнсний үйлдвэр	3	29	Асуулгад хамрагдагчдын талаарх ерөнхий мэдээлэл, хүнсний үйлдвэрийн салбарын бодлого, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, олон улсын төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт
4.	Хөнгөн үйлдвэр	3	12	Асуулгад хамрагдагчдын талаарх ерөнхий мэдээлэл, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, олон улсын төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт

1.6 Мэдээлэл цуглуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулагчдыг тусгайлсан зааварчилгаагаар ханган ажилласан бөгөөд сонгогдсон хэрэглэгчидтэй биечлэн уулзаж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан.

Судалгааны мэдээллийн чанар, бүрэн байдлыг хангахын тулд хяналт тавьж, гарсан асуудлыг дор бүр нь шийдвэрлэн арга хэмжээ авч ажиллалаа.

1.7 Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээлэл боловсруулах ажлыг дараах 2 үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Судалгааны мэдээллийг програмд оруулах

Салбар бүрийн судалгааны мэдээллийг оруулах программыг CsPro 6.3 багц программыг ашиглан гүйцэтгэж, судалгааны мэдээллийг шивэх, шалгах, засварлах ажлыг гүйцэтгэв.

CSPro (Census and Survey Program) програм нь АНУ-ын тооллогын товчооноос боловсруулсан судалгааны мэдээллийг оруулах хамгийн дэвшилтэт програм бөгөөд судалгааны багийн ашигласан CsPro 6.3 хувилбар нь засч сайжруулсан хамгийн сүүлийн хувилбар юм. Энэхүү программыг ашиглан судалгааны мэдээллийг оруулснаар дараах давуу талуудтай. Үүнд:

- Судалгааны асуулгын хуудсанд тохируулан тусгайлсан шивэх программыг боловсруулдаг учраас шивэлтийн үед алдаа гарах, мэдээлэл дутуу шивэгдэхээс сэргийлэх
- Судалгааны хариултыг кодолж өгдөг учраас тухайн кодолж өгсөн утга, эсвэл хязгаараас өөр, буруу утга шивэгдэх боломжгүй
- Судалгааны асуулт хоорондын уялдаа холбоо, үсрэлтийг программын дагуу шалгах боломжтой.

2. Судалгааны мэдээллийг боловсруулах, шинжилгээ хийх

Бэлэн болсон мэдээллийн үр дүнг нэгтгэн боловсруулахдаа IBM SPSS Statistics 20 программыг ашиглан холбогдох статистикийн шинжилгээг хийн, хүснэгт графикуудыг боловсрууллаа.

SPSS програм нь судалгааны мэдээлэлд статистик дүн шинжилгээ хийхэд дэлхий нийтэд хамгийн өргөн хэрэглэгддэг програм юм SPSS программыг ашиглан нийгмийн статистикийн тоон шинжилгээний олон нарийн аргуудаар мэдээллийг богино хугацаанд шинжлэх, үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулах өргөн боломжтой байдаг.

CsPro болон SPSS программууд нь хоорондоо мэдээлэл солилцох бүрэн боломжтой юм.

Судалгааны асуулгыг 1-5 баллаар үнэлэх үнэлгээний аргачлалыг ашигласан бөгөөд өөрөөр хэлбэл хамгийн бага үнэлгээг 1, хамгийн их үнэлгээг 5 балл байхаар тооцсон.

1.8 Судалгааны явцад гарсан хүндрэл бэрхшээл

Энэ удаагийн хэрэглэгчийн үнэлгээний судалгааны ажил цаг хугацааны хувьд маш шахуу байсан өөрөөр хэлбэл захиалагчтай 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр 20170214/09-022 тоот гэрээ байгуулсан гэрээнд 35 хоногт багтаан судалгааг хийх, 3 сарын 15 гэхэд эцсийн тайлангаа нийлүүлэхээр заасан. Гэвч судалгааны асуулга авахад захиалагч болон нийлүүлэгчээс урьдчилан тооцоолоогүй дараах хүчин зүйлүүд шууд нөлөөлж гэрээнд заасан хугацаанд эцсийн тайлангаа нийлүүлэхэд эрсдэлучирсан. Үүнд:


- Монголын ард түмний уламжлалт баяр цагаан сар 3 өдөр үргэлжилж бүх нийтээр амарсан,
- Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын өдөр зэрэг тэмдэглэлт үйл явдал тохиосон, нөгөөтэйгүүр
- Арьс шир, ноолуурын үйлдвэрүүд улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэг учраас үйл ажиллагаа эрхлээгүй цаг хугацаа таарсан.
- Орон нутагт байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдал үүсч зам хаасан
- Малын халдварт өвчин гарч тодорхой хугацаагаар хөл хорио тогтоосон зэрэг урьдчилан төсөөлөөгүй хүндрэлүүд бидний төлөвлөгөөнд нөлөөлсөн.


Хэрэглэгчдээс судалгааны асуулга авахад төлөвлөсөн цаг хугацааны ихэнхийг зарцуулдаг болох нь иймэрхүү төрлийн судалгаанд нийтлэг асуудал байдаг. Иймд цаашдаа цаг хугацааг хэт давчуу бус, нөгөөтэйгүүр дээр дурьдсан шиг гарч болох эрсдлүүдийг давхар тооцсон байхаар цаг хугацааны хувьд төлөвлөлтөд давхар анхаарах нь судалгааны чанар, үр дүн, гэрээний хугацааг мөрдөхөд чухал ач холбогдолтой болох нь энэ удаагийн хэрэглэгчийн үнэлгээний судалгааны явцад ажиглагдлаа.

БҮЛЭГ 2. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

2.1 Судалгаанд хамрагдагчдын ерөнхий мэдээлэл

Мал аж ахуйн салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ 2 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийн нийт 480 хэрэглэгчдийг түүвэр судалгаанд хамрууллаа. Ингэхдээ мал аж ахуй илүү төвлөрсөн Архангай аймагт түүврийн ихэнх хувийг тархаасан бөгөөд судалгаанд хамрагдагчдын 79% нь Архангай аймгийн иргэд байна. Судалгаанд хамрагдагчдын хүйсийн хувьд 30% нь эмэгтэй, 70% эрэгтэй байсан бөгөөд насны ангиллаар авч үзвэл 5% нь 18-25 насны, 15% нь 26-35 ба түүнээс дээш, 24% нь 26-35 насны, 31% нь 36-45 насны хэрэглэгчид байна. Боловсролын түвшингээр авч үзвэл 2% нь сургууль төгссөөгүй, 10% нь техник мэргэжлийн, 11% нь бага сургууль, 18% нь дээд сургууль төгссөн, 27% нь бүрэн дунд, 32% нь суурь боловсролтой байна. Судалгаанд хамрагдагчдын 91% нь малчин, 4% нь фермийн эзэн, 4% нь фермийн ажилтан, 1% нь туслах малчин байна.






2.2 Судалгааны үндсэн мэдээлэл

2.2.1 Мал аж ахуйн салбарын бодлогын талаар


Салбарын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд олон нийт, зорилтот бүлэгт мэдээлэл хүргэх нь хамгийн чухал. Судалгаанд хамрагдагчдын 78% нь мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн радио, телевизээс түүнчлэн сум, баг, дүүрэг, хороо, аймгийн удирдлагууд, мэдээлэл авдаг бол 8% нь сонин сэтгүүлээс, 4% хөрш, найз нөхөд, хамаатнаасаа, 4% нь олон нийтийн уулзалт, цуглаанаас, 2% нь интернетээс авдаг харин 1% нь л зарлалын самбар, зурагт хуудаснаас авдаг гэжээ. Үүнээс үзвэл интернет, зарлалын самбар, зурагт хуудас зэргийг төдийлөн анхаардаггүй болох нь ажиглагдлаа. Иймээс мал аж ахуйг салбарт хэрэгжиж буй үйл ажиллагааны мэдээллийг радио, телевизээр түгээх нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй нь харагдаж байна.

Та мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй төрийн бодлогын талаарх мэдээллийг ихэвчлэн ямар эх үүсвэрээс авдаг вэ?



Мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байгаа талаар судалгаанд хамрагдсан 3 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийн хэрэглэгчдийн үнэлгээ 3.84-4.73 хооронд байна. Үүнд Орхон аймгийн хэрэглэгчид 3.84 гэж үнэлсэн бол Улаанбаатар хотын хэрэглэгчид их буюу 4.73 гэж үнэлсэн байна.

Таны бодлоор мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байна вэ?




Үүнээс үзэхэд МАА-н салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байгаа талаар хэрэглэгчдийн дундаж үнэлгээ 4.25 байна.

Малын эмийн хүртээмж, чанар хэр хангагдаж байгаа талаар малчид-хэрэглэгчдээс авсан судалгааны үр дүнгээс үзвэл Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан хэрэглэгчид их буюу 4.82 гэсэн үнэлгээ өгсөн бол Орхон аймгийн хэрэглэгчид 4.24 гэсэн үнэлгээ өгсөн байна.

Малын эмийн хүртээмж, чанар хэр хангагдаж байгаа талаар хэрэглэгчдийн дундаж үнэлгээ 4.46 байна.

Малын эмийн хүртээмж, чанар хангагдаж чадаж байна уу?




2.2.2 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ХАА-н биржийн талаар судалгаанд хамрагдагчдын 68% нь бүрэн мэдээлэлтэй, 12% нь ерөнхийдөө мэднэ, 11% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй гэсэн бол 9% огт мэдээлэлгүй гэжээ. Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдагчид ХАА-н биржийн үйл ажиллагааны талаар харьцангуй мэдээлэл сайтай байгаа нь харагдаж байна.


ХАА-н биржээр дамжуулан малчдын дийлэнх нь буюу 23% нь тогтмол биш, 45% нь 1-2 удаа малын гаралтай түүхий эдээ борлуулсан гэжээ.

Судалгаанд хамрагдагчид ХАА-н биржийн үйл ажиллагааг дунджаар 4.23 оноогоор үнэлсэн бөгөөд үүнд Орхон аймгийн хэрэглэгчид бага буюу 3.8, Улаанбаатар хотын хэрэглэгчид их буюу 4.75 гэсэн үнэлгээ өгсөн байна.


Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?



Танайх малын гаралтай түүхий эдээ хөдөө аж ахуйн биржээр дамжуулан борлуулж байсан уу?




Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа хэр байна вэ?



2.2.3 Төрөөс малчдын талаар баримтлах бодлого


Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын талаар судалгаанд хамрагдагчдын 31% нь ерөнхийдөө мэднэ, 43% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, 22% нь огт мэдээлэлгүй байна. Судалгаанд хамрагдагчдын ердөө 4% нь энэ бодлогын талаар бүрэн мэдээлэлтэй гэж хариулжээ. Үүнээс үзэхэд төрөөс малчдын талаар баримтлах бодлогын талаар энэ удаагийн судалгаанд хамрагдагчид мэдээлэл сайтай байгаа нь харагдаж байна.

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?



Харин төрөөс малчдын талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр ямар нэг мэдэгдэхүйц ахиц гарсан эсэх талаар асуухад судалгаанд оролцогчдын 31% нь ахиц гарсан гэж хариулсан бөгөөд бодлогын хэрэгжилтийн үр дүнд амьжиргаа сайжирсан, нийгмийн хамгааллын баталгаа бий болсон, ажлын байр нэмэгдсэн, мэдлэг чадвар сайжирсан зэрэг эерэг ахиц, өөрчлөлтийг дурдсан байна. Харин судалгаанд хамрагдагчдын 40% нь ямар нэг ахиц гараагүй, 29% нь мэдэхгүй гэжээ.

Төрөөс малчдын талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр танай өрх, эсвэл байгууллагад мэдэгдэхүйц ахиц гарсан уу?




Ямар мэдэгдэхүйц ахиц гарсан бэ?



Мал малласнаар малчин айл өрх өрхийн хэрэглээгээ бүрэн хангаж чадаж байгаа эсэхэд судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн үнэлгээ 4.13-4.54 байгаа бөгөөд дундаж үнэлгээ 4.34 байна. Судалгаанд хамрагдагчдын 79% нь Архангай аймгийн хэрэглэгчид байсан бөгөөд тэд мал малласнаар малчин айл өрх өрхийн хэрэглээгээ бүрэн хангаж чадаж байгаа эсэхэд 4.36 гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь төрөөс малчдын талаар баримтлах бодлого, хэрэгжилтэд хэрэглэгчид сэтгэл ханамжтай байгааг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг юм.

Мал малласнаар өрхийн хэрэглээгээ бүрэн хангаж чаддаг уу?




2.2.4 Үндэсний төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт

“Монгол мал” үндэсний хөтөлбөр


“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 6% нь бүрэн мэдээлэлтэй, 27% нь ерөнхийдөө мэднэ, 41% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 26% нь огт мэдээлэлгүй байна.

Та “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн талаар хэр мэдээлэлтэй байна вэ?




Тус хөтөлбөр хэрэгжсэнээр ямар нэгэн мэдэгдэхүйц ахиц гарсан эсэхэд судалгаанд хамрагдагчдын 27% нь ахиц гарсан гэж үзэж байна. Үүнд амьжиргаа сайжирсан, мал эмнэлгийн үйлчилгээ сайжирсан, усан хангамж сайжирсан зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр танай өрх, эсвэл байгууллагад мэдэгдэхүйц ахиц гарсан уу?




Ямар мэдэгдэхүйц ахиц гарсан бэ?




Малын үржил, ашиг шимийн гарц нэмэгдүүлэх тал дээр сургалт, судалгаа, туршлага солилцох зэрэг төрийн дэмжлэг хэр байна вэ гэсэн асуултанд судалгаанд хамрагдагчид 4.2-4.49 гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд дундаж үнэлгээ 4.32 байна. Энэ нь малын үржил, ашиг шимийн гарц нэмэгдүүлэх тал дээр сургалт, судалгаа, туршлага солилцох зэрэгт төрөөс үзүүлж буй бодлого, хэрэгжилтэд хэрэглэгчид сэтгэл ханамжтай байгааг харуулж байна.

Малын үржил, ашиг шимийн гарц нэмэгдүүлэх тал дээр сургалт, судалгаа, туршлага солилцох зэрэг төрийн дэмжлэг хэр байна вэ?




Мал эмнэлэг, малын эмчийн хүртээмж, үйлчилгээний чанарын талаар судалгаанд хамрагдсан малчид дунджаар 4.27 гэсэн үнэлгээ өгсөн байна.

Мал эмнэлэг, малын эмчийн хүртээмж, үйлчилгээний чанар хэр байна вэ?



“Сайн малчин” хөтөлбөрийн хэрэгжилтэнд судалгаанд хамрагдсан малчид 4.38 гэсэн үнэлгээ өгч байна.

Та “Сайн малчин” хөтөлбөрийн хэрэгжилтэнд хэр сэтгэл хангалуун байна вэ?



2.2.5 Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Энэ удаагийн судалгаанд хамрагдагчид олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн талаар судалгаанд хамрагдагчид мэдээлэл сайтай байгааг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 2.2.5.1

Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үнэлгээ

	Төсөл, хөтөлбөрүүд	Та дараах төсөл, хөтөлбөрүүдийн талаар хэр сайн мэдэх вэ?	Та дараах төсөл, хөтөлбөрүүдийн үйлжиллагаанд үнэлгээ өгнө үү?
1.	“Ногоон алт” төсөл	4.61	4.53
2.	“Малын эрүүл мэнд” төсөл	4.26	4.22
3.	Малыг ялган тэмдэглэх - анхан шатны бүртгэлд авах	4.24	4.30
4.	Уур амьсгалын өөрчлөлтөнд зохицсон хөдөөгийн амьжиргаа	4.17	4.25
5.	Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент	4.40	4.08
6.	“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл (Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан)	2.28	2.13
7.	"Монгол Улс дахь Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил-II" төсөл(ХБНГУ-ын ХХААЯ)	4.20	1.80
8.	"Хөдөө аж ахуйн маркетинг" төсөл (Даян дэлхийн хүнсний баталгаат байдал хөтөлбөр)	2.90	2.52
9.	“Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн өртөгийн сүлжээг хөгжүүлэх” төсөл (Европын холбоо)	2.80	4.42
	Дундаж	3.76	3.58

МАН-н салбарт төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн үнэлгээг нэгтгэхдээ салбарын бодлого, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016 оны нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийн зорилт, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийн талаарх хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээнд дүн шинжилгээг хийж, үнэлгээг гаргалаа. Үүнд:

Хүснэгт 2.2.5.2

Мал аж ахуйн салбарт төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн үнэлгээ

Бүлэг		Асуулгын үр дүн	
1	Төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт	Мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байгаа талаар	4.25
		Малын эмийн хүртээмж, чанар хэр хангагдаж байгаа талаар	4.46
		Иргэд хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар	4.23
		Мал малласнаар малчин айл өрх өрхийн хэрэглээгээ бүрэн хангаж чадаж байгаа эсэх	4.34
		Малын үржил, ашиг шимийн гарц нэмэгдүүлэх тал дээр сургалт, судалгаа, туршлага солилцох зэрэг төрийн дэмжлэг хэр байна вэ	4.32
2	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Мал эмнэлэг, малын эмчийн хүртээмж, үйлчилгээний чанарын талаар	4.27
		Сайн малчин хөтөлбөрийн хэрэгжилт	4.38
3	Олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	Төсөл, хөтөлбөрүүдийн талаар хэр сайн мэдэх вэ?	3.76
		Төсөл, хөтөлбөрүүдийн нүйлжиллагаанд үнэлгээ өгнө үү?	3.58
		Ерөнхий дундаж үнэлгээ	4.18

БҮЛЭГ 3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

3.1 Судалгаанд хамрагдагчдын ерөнхий мэдээлэл

Газар тариалангийн салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Сэлэнгэ, Орхон аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийн нийт 292 хэрэглэгчдийг түүвэр судалгаанд хамрууллаа.


Судалгаанд хамрагдагчдын 41% нь Сэлэнгэ, 24% нь Орхон аймгийн, 35% нь Улаанбаатар хотын хэрэглэгчид байлаа.

Судалгаанд хамрагдагчдын 45% нь эмэгтэй, 55% эрэгтэй байсан бөгөөд насны ангиллаар авч үзвэл 4% нь 18-25 насны, 12% нь 26-35 насны, 32% нь 36-45 насны, 26% нь 46-54 насны, 26% нь 55 ба түүнээс насны хэрэглэгчид байна.

Боловсролын түвшингээр авч үзвэл 1% нь бага, 13% нь суурь, 30% нь бүрэн дунд, 17% нь техник мэргэжлийн, 39% нь дээд боловсролтой боловсролтой байна.


Судалгаанд хамрагдагчдын 19% нь удирдах ажилтан, 4% нь ажилтан, 77% нь өрхийн тариаланч байна. Өөрөөр хэлбэл нийт судалгаанд хамрагдагчдын 23% нь аж ахуйн нэгжийн төлөөлөл, 77% нь иргэд байна.

Судалгаанд хамрагдагчид, насны бүлгээр




■ 18-25 ■ 26-35 ■ 36-45
■ 46-54 ■ 55+

Судалгаанд хамрагдагчид, хүйсээр




■ Эрэгтэй ■ Эмэгтэй

Судалгаанд хамрагдагчид, боловсролын түвшингээр




■ Бага ■ Суурь
■ Бүрэн дунд ■ ТМД
■ Дээд




3.2 Газар тариалангийн салбарын бодлого

Судалгаанд хамрагдагч газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч-аж ахуйн нэгжийг үйл ажиллагааны төрлөөр ангилан харвал 37% нь үр тариа, 32% нь төмс, хүнсний ногоо, 13% нь жимс, жимсгэнэ, 9% нь хүлэмжийн аж ахуй, 5% нь үр, үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бол үлдсэн 4% нь бусад гэж хариулсан байна.




Харин өрхийн тариалан эрхлэгч иргэдийг тариалангийн төрлөөр үзвэл 64% нь төмс, хүнсний ногоо, 27% нь жимс, жимсгэнэ, 9% нь үр тариа эрхэлж байна.




Судалгаанд хамрагдагчид газар тариалангийн салбарт хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн радио, телевизээс болон интернетээс авдаг болох харагдаж байна. Эдгээр эх үүсвэрээс дийлэнх нь мэдээллээ авдаг болох нь судалгаанд хамрагдагчдын 47% нь хариулсан байдлаас харагдаж байна. Үүний дараа интернэт (12%) болон олон нийтийн уулзалт, цуглаанаас авдаг (9%) гэж хариулжээ. Зарлалын самбар, зурагт хуудаснаас төдийлөн мэдээлэл авдаггүй буюу ердөө 2% нь үүнээс мэдээлэл авдаг гэжээ.

Та газар тариалангийн салбарт хэрэгжиж буй төрийн бодлогын талаарх мэдээллийг ихэвчлэн ямар эх үүсвэрээс авдаг вэ?



Газар тариалангийн салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байгаа талаар хэрэглэгчдийн дундаж үнэлгээ 4.38 гарч байгаа бөгөөд үүнд Улаанбаатар хотын хэрэглэгчид 4.23, Сэлэнгэ аймгийн хэрэглэгчид 4.60 харин Орхон аймгийн хэрэглэгчид 4.30 гэсэн үнэлгээ өгсөн байна.


Таны бодлоор газар тариалангийн салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байна вэ?



3.3 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр


Судалгаанд хамрагдагчид хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх бодлогын талаар харьцангуй багамдээлэлтэй буюу нийт хамрагдагчдын 9% нь бүрэн мэдээлэлтэй, 38% нь ерөнхийдөө мэднэ гэсэн бол 19% нь сонсож байсан, 34% нь огт мэдээлэлгүй гэсэн хариулт өгсөн байна.

Хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх бодлогын талаар хэр зэрэг мэдээлэлтэй байна вэ?




Хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтэнд судалгаанд оролцогчид дунджаар 4.33 үнэлгээ өгсөн байна.

Хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтэнд та хэр сэтгэл хангалуун байна вэ?




Харин танай нутагт хүнсний ногооны тариалалт, хураалт механикжиж, агуулахын аж ахуй хөгжиж чадаж байна уу? гэсэн асуултанд дунджаар 4.21 үнэлгээ өгсөн байна.

Танай нутагт хүнсний ногооны тариалалт, хураалт механикжиж, агуулахын аж ахуй хөгжиж чадаж байна уу?




Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлогын талаар судалгаанд хамрагдагчдын 5% нь бүрэн мэдээлэлтэй, 34% нь ерөнхийдөө мэднэ, 21% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 40% нь огт мэдээлэлгүй гэсэн хариу өгсөн байна.

Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлогын талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?




Тус бодлогын талаар мэдээлэлтэй хэрэглэгчдийн 14% нь төсөлд хамрагдсан бөгөөд төслийн үр дүнг дунджаар 4.60 гэж үнэлсэн байна.

Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлогын хүрээнд төсөлд хамрагдсан уу?




Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлогын хэрэгжилтэнд та хэр сэтгэл хангалуун байна вэ?




Төсөлд хамрагдагчдын 43% нь зээл авсан, 20% нь сургалтад хамрагдсан, 17% нь үр бордооны зээл авсан, 10% нь эргэлтийн талбайгаа нэмэгдүүлсэн гэсэн бол 10% нь техникийн дэмждэг авсан байна. Харин төсөлд хамрагдсанаар 31% нь байнгын ажил, орлоготой болсон, 25% нь усалгааны төхөөрөмжтэй болсон, 25% нь тариалангийн талбай нэмэгдсэн, 19% нь нэг га талбайгаас авах ургац нэмэгдсэн гэжээ. Үүнээс үзвэл төсөл, хөтөлбөр хэрэглэгчдэд тодорхой хэмжээгээр үр ашгаа өгсөн байна.

Та уг төсөлд хамрагдаж ямар үйлчилгээ авсан бэ?



- Зээл авсан
- Сургалтанд хамрагдсан
- Үр, бордооны дэмжлэг авсан
- Эргэлтийн талбайгаа нэмэгдүүлсэн
- Техникийн дэмжлэг авсан

Хөтөлбөрт хамрагдсанаар ямар үр дүн гарсан бэ?




- Байнгын ажил, орлоготой болсон
- Усалгааны төхөөрөмжтэй болсон
- Тариалангийн талбай нэмэгдсэн
- Нэг га талбагаас авах ургац нэмэгдсэн

3.4 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

Газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг бага хүүтэй, урт хугацаатай зээлээр худалдан авах нөхцөл бүрдэж чадаж байгаа эсэхэд судалгаанд хамрагдагчид дунджаар 4.15 үнэлгээ өгчээ.

Газартариалангийн техник, тоног төхөөрөмжийг бага хүүтэй, урт хугацаатай зээлээр худалдан авах нөхцөл бүрдэж чадаж байгаа эсэхэд газар тариалан түлхүү эрхэлдэг Сэлэнгэ аймгийн хэрэглэгчид 4.30, Орхон аймгийн хэрэглэгчид 4.20 гэсэндундаж үнэлгээ өгчээ.

Газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг бага хүүтэй, урт хугацаатай зээлээр худалдан авах нөхцөл бүрдэж байна уу?




3.5 Үндэсний төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт

3.5.1 “Чацаргана” хөтөлбөр

Чацаргана хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 10% нь бүрэн мэдээлэлтэй, 26% нь ерөнхийдөө мэднэ, 17% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 47% нь огт мэдээлэлгүй гэсэн хариу өгсөн байна.

Та “Чацаргана” хөтөлбөрийн талаар хэр мэдээлэлтэй байна вэ?




- Бүрэн мэдээлэлтэй
- Ерөнхийдөө мэднэ
- Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй
- Огт мэдээлэлгүй


Тус бодлогын талаар мэдээлэлтэй иргэдийн 27% нь төсөлд хамрагдсан бол тэдгээрийн 73% нь суулгац авсан, 12% нь зээл авсан, 10% нь сургалтад хамрагдсан, харин үлдсэн 5% нь үр бордооны дэмжлэг авсан байна.

Төсөлд хамрагдсан Сэлэнгэ, Орхон, Улаанбаатар хотын хэрэглэгчдийн 29% нь техник, технологи сайжирсан, 26% нь байнгын ажил, орлоготой болсон, 22% нь тариалангийн талбай нэмэгдсэн, 13% нь нэг га талбайгаас авах ургац нэмэгдсэн зэрэг эерэг ахиц өөрчлөлтийг дурьдаад хөтөлбөрийн үр дүнг дунджаар 4.45 оноогоор үнэлсэн байна.


Та “Чацаргана” хөтөлбөрийн хүрээнд төсөлд хамрагдсан уу?



“Чацаргана” хөтөлбөрийн хэрэгжилтэнд та хэр сэтгэл хангалуун байна вэ?



Та уг төсөлд хамрагдаж ямар үйлчилгээ авсан бэ?




Хөтөлбөрт хамрагдсанаар ямар үр дүнг гарсан бэ?




3.5.2 “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах” богино хугацааны хөтөлбөр

Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд судалгаанд хамрагдагчдын 8% нь зээлд хамрагдсан байна. Зээлд хамрагдсан иргэд хөтөлбөрийн үр дүнг дунджаар 4.00 оноогоор үнэлсэн байна.

Та “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд зээлд хамрагдсан уу?



Хөтөлбөрийн хэрэгжилтэнд та хэр сэтгэл хангалуун байна вэ?



3.6 Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Судалгаанд хамрагдсан амйаг, дүүргийн хэрэглэгчидолон улсын төсөл, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл сайтай байлаа.

Хүснэгт 3.6.1 Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн үнэлгээ

	Төсөл, хөтөлбөрүүд	Та дараах төсөл, хөтөлбөрүүдийн талаар хэр сайн мэдэх вэ?	Та дараах төсөл, хөтөлбөрүүдийн үйлжиллагаанд үнэлгээ өгнө үү?
1	"Монгол ногоо" хөтөлбөр (Швейцарийн хөгжлийн агентлаг)	4.50	4.45
2	Монгол орны нөхцөлд хүлэмжийн лоолийн эрлийз үр үйлдвэрлэлийг хөгжүүлэх (АФАСИ)	4.00	4.50
3	Халх гол төсөл (КОЙКА)	4.50	4.00
4	"Монгол Улс дахь Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил-II" төсөл (ХБНГУ-ын ХХААЯ)	4.25	4.50
5	"Хөдөө аж ахуйн маркетинг" төсөл (Даян дэлхийн хүнсний баталгаат байдал хөтөлбөр)	4.00	4.00
	Дундаж үнэлгээ	4.25	4.29

Газар тариалангийн салбарт хэрэгжиж буй бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээдараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3.6.2 Газар тариалангийн салбарт төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийн үнэлгээ

	Бүлэг	Асуулгын үр дүн	
1	Төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт	Хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт	4.33
		Газар тариалангийн салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байгаа талаар	4.38
		Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлогын үр дүн	4.60
		Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт	4.15
2	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Чацаргана хөтөлбөрийн хэрэгжилт	4.45
		Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах" богино хугацааны хөтөлбөр	4.00
3	Олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	Төсөл, хөтөлбөрүүдийн талаар хэр сайн мэдэх вэ?	4.25
		Төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд үнэлгээ өгнө үү?	4.29
		Ерөнхий дундаж үнэлгээ	4.31

БҮЛЭГ 4. ХҮНСНИЙ САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ**4.1 Судалгаанд хамрагдагчдын ерөнхий мэдээлэл**

Хүнсний салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Архангай, Орхон, Сэлэнгэ аймгууд болон Улаанбаатар хотын 3 дүүргийг хамруулан нийт 680 иргэнийг түүвэр судалгаанд хамруулсан. Ингэхдээ Улаанбаатар хотод түүврийн ихэнх хувийг тархаасанбөгөөд нийт судалгаанд хамрагдагчдын 69% нь Улаанбаатар хотын хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид байна.


Судалгаанд хамрагдагчдын 44% нь эмэгтэй, 56% эрэгтэй байсан бөгөөд насны ангиллаар авч үзвэл 10% нь 18-25 насны, 27% нь 26-35 насны, 33% нь 36-45 насны, 22% нь 46-54 насны, 8% нь 55 ба түүнээс дээш насны хэрэглэгчид байна.

Боловсролын түвшингээр авч үзвэл 2% нь бага, 6% нь суурь, 23% нь бүрэн дунд, 10% нь техник мэргэжлийн, 59% нь дээд боловсролтой боловсролтой байна.

Судалгаанд хамрагдагчдыг байршлаар нь үзвэл 31% нь Баянзүрх дүүргийн, 22% нь Хан-уул дүүргийн, 16% нь Сонгинохайрхан дүүргийн, 22% нь Орхон аймгийн, 7% нь Сэлэнгэ, 2% нь Архангай аймгийн хэрэглэгчид байлаа.


Судалгаанд хамрагдагчдын 52% нь удирдах ажилтан, 48% нь ажилтнууд байлаа.

Судалгаанд хамрагдагчид, насны бүлгээр




■ 18-25 ■ 26-35 ■ 36-45
■ 46-54 ■ 55+

Судалгаанд хамрагдагчид, хүйсээр




■ Эрэгтэй ■ Эмэгтэй

Судалгаанд хамрагдагчид, боловсролын түвшингээр




■ Бага ■ Суурь
■ Бүрэн дунд ■ ТМД
■ Дээд

Судалгаанд хамрагдагчид, байршлаар



■ Архангай
■ Орхон
■ Сэлэнгэ
■ Баянзүрх
■ Сонгинохайрхан
■ Хан-Уул

Албан тушаал




■ Удирдах ажилтан ■ Ажилтан

4.2 Хүнсний салбарын бодлого

Хүнсний салбарын бодлогын хэрэгжилтийг үнэлэх судалгаанд тус салбарын үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрлэлийн төрлөөр харьцангуй жигд хуваарилагдан хамрагдсан байна.

Танайх хүнсний салбарт ямар төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг вэ?




■ Сүү, сүүн бүтээгдэхүүн
■ Мах, махан бүтээгдэхүүн
■ Гурил, гурилан бүтээгдэхүүн
■ Исгэлтийн үйлдвэрлэл (архи, пиво, ус, ундаа, шүүс)
■ Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ
■ Бусад

Салбарын хуваарилалтыг байршлаар харвал:(хувиар)


	Хан-Уул	СХД	Баянзүрх	Сэлэнгэ	Орхон	Архангай
Сүү, сүүн бүтээгдэхүүн	31,8	14,7	10,4	25,0	26,0	40,0
Мах, махан бүтээгдэхүүн	13,6	30,5	25,8	15,0	15,7	20,0
Гурил, гурилан бүтээгдэхүүн	14,4	32,6	40,1	32,5	27,6	40,0
Исгэлтийн үйлдвэрлэл (архи, пиво, ус, ундаа,шүүс)	11,4	11,6	13,2	5,0	1,6	
Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ	15,2	3,2	4,4	2,5	13,4	
Бусад	13,6	7,4	6,0	20,0	12,7	
Нийт	100	100	100	100	100	100

Судалгаанд хамрагдагчид хүнсний салбарт хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн радио, телевизээс болон интернетээс авч байна.



Хүнсний салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байгаа талаар хэрэглэгчдийн дундаж үнэлгээ 4.25 байна.

Таны бодлоор хүнсний салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байна вэ?




4.3 Үндэсний төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт

4.3.1 Хүнсний аюулгүй байдал хөтөлбөр

Хүнсний аюулгүй байдал хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 14% нь бүрэн мэдээлэлтэй, 38% нь ерөнхийдөө мэднэ, 21% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 27% нь огт мэдээлэлгүй байна.

Та “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийн талаар хэр мэдээлэлтэй байна вэ?



Байршил(хувиар):

	АР	ОР	СЭ	УБ
Бүрэн мэдээлэлтэй	10,0	13,4	2,5	15,1
Ерөнхийдөө мэднэ	40,0	53,	35,0	33,7
Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	50,0	18,	32,5	19,1
Огт мэдээлэлгүй		12,6	30,0	32 2
Нийт	100	100	100	100


“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй эсэхийг үйлдвэрлэлийн төрлөөр харвал:

(хувиар)

	Бүрэн мэдээлэлтэй	Ерөнхийдөө мэднэ	Сонсожбайсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	Огт мэдээлэлгүй	Нийт
Сүү, сүүн бүтээгдэхүүн	13,9	39,3	24,6	22,1	100
Мах, махан бүтээгдэхүүн	18,2	41,3	18,2	22,3	100
Гурил, гурилан бүтээгдэхүүн	11,6	38,2	18,5	31,8	100
Исгэлтийн үйлдвэрлэл (архи, пиво, ус, ундаа, шүүс)	9,3	37,0	22,2	31,5	100
Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ	6,1	46,9	14,3	32,7	100
Бусад	20,0	25,0	26,7	25,0	100


Тус хөтөлбөрийн хүрээнд судалгаанд хамрагдагчдын 5% нь сургалт, тоног төхөөрөмж, зээл хэлбэрээр дэмжлэг авсан байна.

Та “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийн хүрээнд ямар нэг дэмжлэг авсан уу?



“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийн хэрэгжилтийг судалгаанд хамрагдагчид дунджаар 4.24 оноогоор үнэлсэн байна.

“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийн хэрэгжилтэнд та хэр сэтгэл хангалуун байна вэ? (1-5 оноогоор үнэлнэ үү)



Хүнсний салбарт хэрэгжиж буй бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 4.1 Хүнсний салбарт төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийн үнэлгээ

д/д	Бүлэг	Асуулгын үр дүн
1	Төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт	4.25
2	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	4.24
	Ерөнхий дундаж үнэлгээ	4.24

БҮЛЭГ 5. ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

5.1 Хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн ерөнхий мэдээлэл


Хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Архангай, Орхон, Сэлэнгэ аймгууд болон Улаанбаатар хотын 3 дүүргийг хамруулан нийт 607 иргэнийг түүвэр судалгаанд хамруулан авсан. Ингэхдээ Улаанбаатар хотод түүврийн ихэнх хувийг тархаасан бөгөөд нийт судалгаанд хамрагдагчдын 84% нь Улаанбаатар хотын хөнгөн үйлдвэр эрхлэгчид байна.

Судалгаанд хамрагдагчдын 47% нь эмэгтэй, 53% эрэгтэй байсан бөгөөд насны ангиллаар авч үзвэл 4% нь 18-25 насны, 31% нь 26-35 насны, 37% нь 36-45 насны, 21% нь 46-54 насны, 7% нь 55 ба түүнээс дээш насны хэрэглэгчид байна.

Боловсролын түвшингээр авч үзвэл 1% нь бага, 3% нь суурь, 18% нь бүрэн дунд, 13% нь техник мэргэжлийн, 65% нь дээд боловсролтой боловсролтой байна.

Судалгаанд хамрагдагчдыг байршлаар нь үзвэл 8% нь Баянзүрх дүүргийн, 50% нь Хан-Уул дүүргийн, 26% нь Сонгинохайрхан дүүргийн, 10% нь Орхон аймгийн, 4% нь Сэлэнгэ, 2% нь Архангай аймгийн хэрэглэгчид байлаа.

Судалгаанд хамрагдагчдын 52% нь удирдах ажилтан, 48% нь ажилтнууд байна.



5.2 Хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого

Хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын хэрэгжилтийг үнэлэх судалгаанд тус салбарын үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрлэлийн төрлөөр харьцангуй жигд хуваарилагдан хамрагдсан байна.




Салбарын хуваарилалтыг байршлаар харвал:

(хувиар)


	Хан-Уул	Сонгинохайрхан	Баянзүрх	Сэлэнгэ	Орхон	Архангай
Ноос, ноолууран бүтээгдэхүүн	25,6	8,7	36,4		11,1	62,5
Арьс ширэн бүтээгдэхүүн	22,8	27,0	18,2		13,3	
Оёмол бүтээгдэхүүн	7,8	8,7	18,2	5,6	26,7	
Мод, модон эдлэл	5,5	14,8	6,1	61,1	13,3	
Хэвлэл	12,3	7,0	3,0		4,4	
Цахилгаан хэрэгсэл	1,8	1,7				
Сав, баглаа боодол	5,9	7,0			2,2	
Барилгын материал	10,0	14,8	3,0	16,7	2,2	
Дахин боловсруулах	0,5					
Бусад	7,8	10,4	15,2	16,7	26,7	37,5
Нийт	100	100	100	100	100	100

Судалгаанд хамрагдагчид хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн радио, телевиз(34%)-ээс авч байна. Түүнчлэн баг, хорооны удирдлагуудаас мэдээлэл (20%) авдаг нь харагдаж байна. Харин интернетээс мэдээлэл авах нь бага буюу судалгаанд хамрагдагчдын 3% нь байна.



Хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байгаа талаар хэрэглэгчдийн дундаж үнэлгээ 4.24 байна.


Таны бодлоор хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байна вэ?



5.3 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Судалгаанд хамрагдагчид боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилготой Хөгжлийн банкнаас олгох хөнгөлөлттэй зээлийн талаар 9% нь бүрэн мэдээлэлтэй, харин 31% нь огт мэдээлэлгүй байна.

Боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилготой Хөгжлийн банкнаас олгох хөнгөлөлттэй зээлийн талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?




Байршлаар (хувиар):

	АР	ОР	СЭ	УБ
Бүрэн мэдээлэлтэй	25,0	4,4	11,1	8,4
Ерөнхийдөө мэднэ	25,0	22,2	3,3	24,3
Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	37,5	31,1	50,0	36,2
Огт мэдээлэлгүй	12,5	42,2	5,6	31,1
Нийт	100	100	100	100

Ноолуур, арьс шир, ноос, махны үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санг нэмэгдүүлэх бодлогын талаар судалгаанд хамрагдагчдын 6% нь бүрэн мэдээлэлтэй, харин 37% нь огт мэдээлэлгүй байна.

Судалгаанд хамрагдагчид хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн радио, телевизээс болон интернетээс авч байна.


Та хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй төрийн бодлогын талаарх мэдээллийг ихэвчлэн ямар эх үүсвэрээс авдаг вэ?



- Радио, телевиз
- Интернет
- Бусад
- Сонин, сэтгүүл
- Мэргэжлийн холбоод
- Олон нийтийн уулзалт цуглаан
- Сум, дүүрэг, аймгийн удирдлагууд
- МҮХАҮТ
- Зарлалын самбар, зурагт хуудас

Ноолуур, арьс шир, ноос, махны үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санг нэмэгдүүлэх бодлогын талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?

Байршил (хувиар):




	АР	ОР	СЭ	УБ
Бүрэн мэдээлэлтэй	25,0	4,4	11,1	5,4
Ерөнхийдөө мэднэ	25,0	22,2	50,0	22,6
Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	50,0	37,8	33,3	32,7
Огт мэдээлэлгүй	0	35,6	5,6	39,3
Нийт	100	100	100	100

Ноолуур, арьс шир, ноос, махны үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд судалгаанд хамрагдагчдын 17% нь хөнгөлөлттэй зээл авсан байна.

Ноолуур, арьс шир, ноос, махны үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан уу?


Байршлаар (хувиар):



	АХ	ОР	СЭ	УБ
Тийм	12,5	6,7	11,1	18,3
Үгүй	87,5	93,3	88,9	81,7
Нийт	100	100	100	100

Тус зээлд хамрагдсанаар хүрсэн үр дүнг тодруулахад судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь буюу 27% нь техник, технологи сайжирсан гэж хариулсан байна.


Хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсанаар ямар үр дүн гарсан бэ?



- Техник, технологи сайжирсан
- Бүтээгдэхүүний чанар сайжирсан
- Бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэн
- Үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн
- Ажлын байр нэмэгдсэн
- Гадаадад бүтээгдэхүүнээ борлуулдаг болсон


Ноолуур, арьс шир, ноос, махны болон бусад боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зээлийг нэмэгдүүлэх тус бодлогын үр дүнг судалгаанд оролцогчид дунджаар 4.19 оноогоор үнэлж байна.

Ноолуур, арьс шир, ноос, махны болон бусад боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зээлийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийн явцад та хэр сэтгэл хангалуун байна вэ?



Аймгуудын нэгдсэн захыг эрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв болгох бодлогын хэрэгжилтийн явцын талаар орон нутгаас судалгаанд хамрагдагчдын 4% нь бүрэн мэдээлэлтэй, харин 38% нь огт мэдээлэлгүй байна.

Аймгуудын нэгдсэн захыг эрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв болгох бодлогын хэрэгжилтийн явцын талаар хэр зэрэг мэдээлэлтэй байна вэ?




Байршлаар (хувиар):

	АР	ОР	СЭ
Бүрэн мэдээлэлтэй	12,5	2,2	5,6
Ерөнхийдөө мэднэ	25,0	15,6	50,0
Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	12,5	37,8	27,8
Огт мэдээлэлгүй	50,0	44,4	16,7
Нийт	100	100	100


Танай аймгийн нэгдсэн зах эрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв болж чадсан эсэхэд судалгаанд хамрагдагчид дунджаар 4.13 гэсэн үнэлгээ өгсөн байна.

Танай аймгийн нэгдсэн зах эрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв болж чадсан уу?



Харин тус бодлогын хэрэгжилтийн явцын талаар дунджаар 4.40 гэсэн үнэлгээ өгчээ.

Аймгуудын нэгдсэн захыг эрүүл ахуйн шаардлага хангасан бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв болгох бодлогын хэрэгжилтийн явцын талаар хэр зэрэг сэтгэл хангалуун байна вэ?




5.4 Үндэсний төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт

5.4.1 Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр

Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 5% нь бүрэн мэдээлэлтэй, 27% нь ерөнхийдөө мэднэ, 38% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 30% нь огт мэдээлэлгүй байна.

Та Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн талаар хэр мэдээлэлтэй байна вэ?



Байршил (хувиар):


	АР	ОР	СЭ	УБ
Бүрэн мэдээлэлтэй	25,0	4,4	27,8	4,1
Ерөнхийдөө мэднэ	25,0	17,8	38,9	27,0
Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	25,0	46,7	16,7	37,9
Огт мэдээлэлгүй	25,0	31,1	16,7	31,1
Нийт	100	100	100	100

Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй эсэхийг үйлдвэрлэлийн төрлөөр харвал:

	Бүрэн мэдээлэлтэй	Ерөнхийдөө мэднэ	Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	Огт мэдээлэлгүй	Нийт
Ноос, ноолуур	4,5	31,8	29,5	34,1	100
Арьс шир	1,1	36,6	37,6	24,7	100
Оёмол	13,0	19,6	45,7	21,7	100
Мод, модон эдлэл	10,4	25,0	22,9	41,7	100
Хэвлэл	2,6	18,4	47,4	31,6	100
Цахилгаан хэрэгсэл	16,7	50,0	33,3	0	100
Сав, баглаа боодол	0	27,3	27,3	45,5	100
Барилгын материал	0	25,0	56,8	18,2	100
Дахин боловсруулах		100			100
Бусад	11,5	9,6	40,4	38,5	100

Тус хөтөлбөрийн хүрээнд судалгаанд хамрагдагчдын 17% нь төсөлд хамрагдсан байна. Уг төсөлд хамрагдагчдын дийлэнх нь буюу 64% нь зээл авсан байна.

Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн хүрээнд төсөлд хамрагдсан уу?



Байршил(хувиар):

	АР	ОР	СЭ	УБ
Тийм	25,0	8,9	22,2	17,2
Үгүй	75,0	91,1	77,8	82,6
Нийт	100	100	100	100

Та уг хөтөлбөрт хамрагдаж ямар үйлчилгээ авсан бэ?




Харин хөтөлбөрт хамрагдсанаар дараах үр дүн гарчээ. Үүнд шинэ техик, технологи нэвтэрсэн гэж судалгаанд оролцогчдын 23%, үйлдвэрлйн хэмжээ нэмэгдсэн гэж 13%, бүтээгдэхүүний чанар сайжирсан гэж 20%, бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэн гэж 21%, ашиг орлого нэмэгдсэн гэж 23% нь хариулжээ.

Хөтөлбөрт хамрагдсанаар ямар үр дүн гарсан бэ?



Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг судалгаанд хамрагдагчид дунджаар 4.29 оноогоор үнэлсэн байна.


Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэнд та хэр сэтгэл хангалуун байна вэ?



5.2.2 Хоршоог хөгжүүлэх хөтөлбөр

Хоршоог хөгжүүлэх хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 4% нь бүрэн мэдээлэлтэй, 21% нь ерөнхийдөө мэднэ, 36% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 39% нь огт мэдээлэлгүй байна.

Та “Хоршоог хөгжүүлэх” хөтөлбөрийн талаар хэр зэрэг мэдээлэлтэй байна вэ?



Байршил(хувиар):

	АР	ОР	СЭ	УБ
Бүрэн мэдээлэлтэй	25,0	15,6	11,1	2,5
Ерөнхийдөө мэднэ	37,5	48,9	27,8	16,6
Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	12,5	17,8	22,2	39,2
Огт мэдээлэлгүй	25,0	17,8	38,9	41,7
Нийт	100	100	100	100


Хоршоог хөгжүүлэх хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй эсэхийг үйлдвэрлэлийн төрлөөр харвал:

(хувиар)

	Бүрэн мэдээлэлтэй	Ерөнхийдөө мэднэ	Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	Огт мэдээлэлгүй	Нийт
Ноос, ноолуур	5,7	21,6	26,2	45,5	100
Арьс шир	4,3	14,0	43,0	38,7	100
Оёмол	2,2	34,8	32,6	30,4	100
Мод, модон эдлэл	4,2	22,9	35,4	37,5	100
Хэвлэл	5,3	21,1	52,6	21,1	100
Цахилгаан хэрэгсэл		66,7	33,3		100
Сав, баглаа боодол	9,1	13,6	31,8	45,5	100
Барилгын материал		15,9	31,8	52,3	100
Дахин боловсруулах			100		100
Бусад	7,7	19,2	32,7	40,4	100

Тус хөтөлбөрийн хүрээнд судалгаанд хамрагдагчдын 2.7% нь төсөлд хамрагдсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд төсөлд хамрагдсан уу?




Байршил(хувиар):

	АР	ОР	СЭ	УБ
Тийм	37,5	8,9	11,1	0,8
Үгүй	62,5	91,1	88,9	98,9
Нийт	100	100	100	100

Хоршоог хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдагчид хөтөлбөрийн хэрэгжилтийг 4.75 оноогоор үнэлсэн байна.


Хөтөлбөрийн хэрэгжилтэнд та хэр сэтгэл хангалуун байна вэ?



5.2.3 Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр

Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 2% нь бүрэн мэдээлэлтэй, 20% нь ерөнхийдөө мэднэ, 31% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 47% нь огт мэдээлэлгүй байна.

Та “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих” хөтөлбөрийн талаар хэр зэрэг мэдээлэлтэй байна вэ?



Байршил (хувиар):


	АР	ОР	СЭ	УБ
Бүрэн мэдээлэлтэй		4,4		1,6
Ерөнхийдөө мэднэ	50,0	42,2	27,8	16,6
Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	12,5	28,9	33,3	31,6
Огт мэдээлэлгүй	37,5	24,4	38,9	49,9
Нийт	100	100	100	100

Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй эсэхийг үйлдвэрлэлийн төрлөөр харвал:

(хувиар)

	Бүрэн мэдээлэлтэй	Ерөнхийдөө мэднэ	Сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй	Огт мэдээлэлгүй	Нийт
Ноос, ноолуур	1,1	22,7	27,5	47,7	100
Арьс шир		9,7	40,9	49,5	100
Оёмол	2,2	30,4	28,3	39,1	100
Мод, модон эдлэл	2,1	18,8	31,3	47,9	100
Хэвлэл	2,6	26,3	39,5	31,6	100
Цахилгаан хэрэгсэл		33,3	66,7		100
Сав, баглаа боодол	9,1	31,8	13,6	45,5	100
Барилгын материал	2,3	13,6	25,0	59,1	100
Дахин боловсруулах			100		100
Бусад	1,9	23,1	23,1	51,9	100

Тус хөтөлбөрийн хүрээнд судалгаанд хамрагдагчдын 0,7% нь төсөлд хамрагдсан байна.




Байршил(хувиар):

	АР	ОР	СЭ	УБ
Тийм	12,5	2,2		0,3
Үгүй	87,5	97,8	100	99,7
Нийт	100	100	100	100

Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөрт хамрагдагчид хөтөлбөрийн хэрэгжилтийг 4.90 оноогоор үнэлсэн байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд та хэр сэтгэл хангалуун байна вэ?



Хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3.2 Хөнгөн үйлдвэрийн салбарт төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийн үнэлгээ

Бүлэг		Асуулгын үр дүн	
1	Төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт	Хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй бодлого	4.24
		Ноолуур, арьс шир, ноос, махны болон бусад боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зээлийг нэмэгдүүлэх тус бодлогын хэрэгжилт	4.19
		Аймгийн нэгдсэн зах зэрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв болж чадсан эсэх	4.13
		Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт	4.24
2	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт	4.29
		Хоршоог хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт	4.75
		Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт	4.90
		Ерөнхий дундаж үнэлгээ	4.39

БҮЛЭГ 6. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын хэрэгжилтийн талаар хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ захиалагч талын саналын дагуу Архангай, Сэлэнгэ, Орхон аймаг, Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн насанд хүрсэн 2059 хэрэглэгчийг хамрууллаа. Үүнээс МАА-н салбарын 480 (судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 23%), газар тариалангийн салбарын 292 (14%), хүнсний үйлдвэрийн салбарын 680 хэрэглэгч (33%), хөнгөн үйлдвэрийн салбарын 607 хэрэглэгчийг (30%) энэ удаагийн түүвэр судалгаанд хамруулан асуулгын аргачлалыг ашигласны зэрэгцээ асуулгын хариултыг 1-5 баллаар үнэлж, үр дүнг SPSS программаар боловсруулж дүгнэлт гаргав.

6.1 Мал аж ахуйн салбар:

Мал аж ахуйн салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ 2 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийг хамруулан нийт 480 иргэнийг түүвэр судалгаанд хамрууллаа.

МАА-н салбарт төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, төслийн талаар салбарын хэрэглэгч 480 хэрэглэгчээс авсан судалгааны үр дүнг нэгтгэвэл уг салбарт хэрэгжиж буй бодлогын хэрэгжилтийн үнэлгээ **4.23-4.46**, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үнэлгээ **4.27-4.38** байгаа бол олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг **3.76-3.58** гэж үнэлсэн байна.

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн дундаж үнэлгээ энэ салбарт **4.18** буюу **83.5** хувьтайгаар үнэлэгдэж байна.

6.2 Газар тариалангийн салбар:

Газар тариалангийн салбарын хэрэглэгч 292 иргэнээс авсан судалгааны үр дүнгээс харахад газар тариалангийн салбарт төрөөс хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтэд судалгаанд хамрагдагчид **4.15-4.60** гэсэн үнэлгээ өгсөн бол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд **4.00-4.45**, харин олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд **4.00-4.50** гэсэн үнэлгээг тус тус өгсөн байна.

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн дундаж үнэлгээ энэ салбарт **4.31** буюу **86.1** хувьтайгаар үнэлэгдэж байна.

6.3 Хүнсний салбар:

Хүнсний салбарын хэрэглэгчдийн судалгаанд Архангай, Орхон, Сэлэнгэ аймгууд болон Улаанбаатар хотын 3 дүүргийг хамруулан нийт 680 иргэнийг түүвэр судалгаанд хамруулсан. Ингэхдээ Улаанбаатар хотод түүврийн ихэнх хувийг тархаасан бөгөөд нийт судалгаанд хамрагдагчдын 69% нь Улаанбаатар хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид байлаа.

Энэ салбарын судалгааны үр дүнгээс үзэхэд хүнсний үйлдвэрлэлийн салбарт төрөөс хэрэгжүүлж байгаа бодлогын хэрэгжилтэд судалгаанд хамрагдагчид **4.25**, харин үндэсний төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд **4.24** гэсэн үнэлгээ тус тус өгсөн бөгөөд дундаж үнэлгээ энэ салбарт **4.24** буюу **84.9** хувьтайгаар үнэлэгдэж байна.

Хүнсний салбарт хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийн хамрах хүрээ бага тул судалгаанд хамрагдсан 3 аймаг, 3 дүүргийн хувьд судалгааны асуулгад ороогүй болно.

6.4 Хөнгөн үйлдвэрийн салбар:

Хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Архангай, Орхон, Сэлэнгэ аймгууд болон Улаанбаатар хотын 3 дүүргийн нийт 607 иргэнийг түүвэр судалгаанд хамруулан авсан. Ингэхдээ Улаанбаатар хотод түүврийн ихэнх хувийг тархаасан бөгөөд нийт судалгаанд хамрагдагчдын 84% нь Улаанбаатар хотын хөнгөн үйлдвэр эрхлэгчид байна.

Энэ салбарын судалгааны үр дүнгээс үзэхэд хөнгөн үйлдвэрлэлийн салбарт төрөөс хэрэгжүүлж байгаа бодлогын хэрэгжилтэд судалгаанд хамрагдагчид **4.13-4.24**, үндэсний төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд **4.29-4.90** гэсэн үнэлгээг тус тус өгсөн бөгөөд дундаж үнэлгээ энэ салбарт **4.39** буюу **87.9** хувьтайгаар үнэлэгдэж байна.

БҮЛЭГ 7. “ХХААХҮ-ИЙН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ 2016” СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ХХААХҮ-ийн салбарын хэрэглэгчийн үнэлгээний энэ удаагийн судалгаанд хамрагдсан 2059 хэрэглэгчийн үнэлгээг нэгтгэж салбарын ерөнхий үнэлгээг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 5.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн
ерөнхий үнэлгээ

д/д	Салбар	Дундаж үнэлгээ	
		Балл	Хувь
1.	Мал аж ахуйн салбар	4.18	83.5%
2.	Газар тариалангийн салбар	4.31	86.1%
3.	Хүнсний салбар	4.24	84.9%
4.	Хөнгөн үйлдвэрлэлийн салбар	4.39	87.9%
	Ерөнхий үнэлгээ	4.28	85.6%

Дээрх хүснэгтээс харахад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ **4.28 буюу 85.6** хувьтайгаар үнэлэгдэж байна. Судалгааны үр дүнд үндэслэн салбар бүрээр хийсэн дүгнэлт, зөвлөмжийг танилцуулбал:

1. МАА-н салбарт

Мал аж ахуйн салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ 2 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийн нийт 480 хэрэглэгчдийг түүвэр судалгаанд хамрууллаа.

Ингэхдээ мал аж ахуй илүү төвлөрсөн Архангай аймагт түүврийн ихэнх хувийг тархаасан бөгөөд судалгаанд хамрагдагчдын 79% нь Архангай аймгийн иргэд байлаа.

МАА-н салбарт төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн үнэлгээг нэгтгэхдээ салбарын бодлого, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016 оны нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийн зорилт, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтэд энэ удаагийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчид **4.18** гэсэн үнэлгээ өгсөн байна.

- Судалгаанд хамрагдагчдын 78% нь буюу дийлэнх хэсэг МАА-н салбарт хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн радио, телевизээс түүнчлэн сум, баг, дүүрэг, хороо, аймгийн удирдлагууд, мэдээлэл авдаг бол харин интернет, зарлалын самбар, зурагт хуудас зэргийг төдийлөн анхаардаггүй байна. Иймээс МАА-н салбарт хэрэгжиж буй үйл ажиллагааны мэдээллийг радио, телевизээр түгээх нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй болох нь харагдаж байна.

- Төрөөс малчдын талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр ямар нэг мэдэгдэхүйц ахиц гарсан гарсан гэж судалгаанд хамрагдагчдын 31% нь хариулсан бөгөөд бодлогын хэрэгжилтийн үр дүнд амьжиргаа сайжирсан, нийгмийн хамгааллын баталгаа бий болсон, ажлын байр нэмэгдсэн, мэдлэг чадвар сайжирсан зэрэг эерэг ахиц, өөрчлөлтийг дурдсан байна. Хэрэглэгчдийн саналаас үзвэл үүнд малын тоо толгой их өссөнтэй холбоотойгоор малын бэлчээрийн багтаамж даац хэтэрсэн, ашиглалт муу бэлчээр хүрэлцдэггүй, отор хийх газар нутаг байхгүй, отрын газрыг сум орон нутгийн удирдлагууд анхаарах, малын тэжээл хадлан авахад бэлчээр муу, малын бэлчээрийг 1-2 хүний өмч болгохоос татгалзах, малын бэлчээр байхгүй, бүх газрын нь хувь хүн авч байгаатай холбогдож байна. Аж ахуйн нэгж их болсон учир малын бэлчээргүй болж байгаа, шилжин ирэгч ихтэй, малыг олон төрөл дээр өсгөх боломжгүй, иргэний бэлчээр байхгүй боллоо, хашаа зоож хатгаад байна, мал 500 -гаас дээш бол татвар авдаг байх, бэлчээрийн асуудлаар малчид хоорондоо маргаан их гарах хандлагатай байгаа, усны асуудал, усан хангамж, бэлчээрийн усалгааны асуудлыг шийдэх талаар малчид нээлттэй асуулгаас харагдаж байна.

- Судалгаанд хамрагдагчид ХАА-н биржийн үйл ажиллагааг дунджаар 4.23 оноогоор үнэлсэн бөгөөд үүнд Орхон аймгийн хэрэглэгчид бага буюу 3.8, Улаанбаатар хотын хэрэглэгчид их буюу 4.75 гэсэн үнэлгээ өгсөн байна.

- Судалгаанд хамрагдагчдын 79% нь Архангай аймгийн хэрэглэгчид байлаа. Архангай аймгаас судалгаанд хамрагдсан малчид мал малласнаар малчин айл өрх өрхийн хэрэглээгээ бүрэн хангаж чадаж байгаа эсэхэд 4.36 гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь төрөөс малчдын талаар баримтлах бодлого, хэрэгжилтэд хэрэглэгчид сэтгэл ханамжтай байгааг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг юм.

- Тус хөтөлбөр хэрэгжсэнээр ямар нэгэн мэдэгдэхүйц ахиц гарсан эсэхэд судалгаанд хамрагдагчдын 27% нь ахиц гарсан гэж үзсэн байна. Үүнд амьжиргаа сайжирсан, мал эмнэлгийн үйлчилгээ сайжирсан, усан хангамж сайжирсан зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан байна.

- Малын үржил, ашиг шимийн гарц нэмэгдүүлэх тал дээр сургалт, судалгаа, туршлага солилцох зэрэг төрийн дэмжлэг хэр байна вэ гэсэн асуултанд судалгаанд хамрагдагчид 4.2-4.49 гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд дундаж үнэлгээ 4.32 байна. Энэ нь малын үржил, ашиг шимийн гарц нэмэгдүүлэх тал дээр сургалт, судалгаа, туршлага солилцох зэрэгт төрөөс үзүүлж буй бодлого, хэрэгжилтэд хэрэглэгчдэд сэтгэл ханамжтай байгааг харуулж байна.

- Мал эмнэлэг, малын эмчийн хүртээмж, үйлчилгээний чанарын талаар судалгаанд хамрагдсан малчид дунджаар 4.27 гэсэн үнэлгээ өгсөн байна. “Сайн малчин” хөтөлбөрийн хэрэгжилтэнд судалгаанд хамрагдсан малчид 4.38 гэсэн үнэлгээ өгсөн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд малчид сэтгэл ханамжтай байгааг харуулж байна.

- Харин олон улсын төсөл, хөтөлбөрийн талаар энэ удаагийн судалгаанд хамрагдагчид мэдээлэл дутмаг(3.76) байгаагаас төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээ бага буюу 3.58 байлаа. Иймд олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг аль болох олон сувгаар иргэдэд түгээж мэдээлэл хүргэх нь оновчтой байхаар байна.

2. Газар тариалангийн салбарт

Газар тариалангийн салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Сэлэнгэ, Орхон аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийн нийт 292 хэрэглэгчдийг түүвэр судалгаанд хамрууллаа.

Судалгаанд хамрагдагчдын 41% нь Сэлэнгэ, 24% нь Орхон аймгийн, 35% нь Улаанбаатар хотын хэрэглэгчид байлаа.

- Судалгаанд хамрагдагчид газар тариалангийн салбарт хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн радио, телевизээс болон интернетээс авдаг болох харагдаж байна. Эдгээр эх үүсвэрээс дийлэнх нь мэдээллээ авдаг болох нь судалгаанд хамрагдагчдын 47% нь хариулсан байдлаас харагдаж байна. Үүний дараа интернэт (12%) болонолоннийгийн уулзалт, цуглаанаас авдаг (9%) гэж хариулжээ. Зарлалын самбар, зурагт хуудаснаас төдийлөн мэдээлэл авдаггүй буюу 2% нь үүнээс мэдээлэл авдаг гэжээ.

- Газар тариалангийн салбарт хэрэгжиж буй бодлого хэр оновчтой байгаа талаар хэрэглэгчдийн дундаж үнэлгээ 4.38 гарч байгаа бөгөөд үүнд Улаанбаатар хотын хэрэглэгчид 4.23, Сэлэнгэ аймгийн хэрэглэгчид 4.60 харин Орхон аймгийн хэрэглэгчид 4.30 гэсэн үнэлгээ өгсөн байна.

- Судалгаанд хамрагдагчид хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх бодлогын талаар харьцангуй сул мэдээлэлтэй буюу нийт хамрагдагчдын 9% нь бүрэн мэдээлэлтэй, 38% нь ерөнхийдөө мэднэ гэсэн бол 19% нь сонсож байсан, 34% нь огт мэдээлэлгүй гэсэн хариулт өгсөн байна.

- Хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтэнд судалгаанд оролцогчид дунджаар 4.33 үнэлгээ өгсөн байна.

- Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлогын талаар судалгаанд хамрагдагчдын 5% нь бүрэн мэдээлэлтэй, 34% нь ерөнхийдөө мэднэ, 21% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 40% нь огт мэдээлэлгүй гэсэн хариу өгсөн байна.

- Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлогын талаар хамрагдагчдын талаар мэдээлэлтэй хэрэглэгчдийн 14% нь төсөлд хамрагдсан бөгөөд төслийн үр дүнг дунджаар 4.60 гэж үнэлсэн байна.

- Судалгаанд хамрагдагчдын 43% нь зээл авсан, 20% нь сургалтад хамрагдсан, 17% нь үр бордооны зээл авсан, 10% нь эргэлтийн талбайгаа нэмэгдүүлсэн гэсэн бол 10% нь техникийн дэмжлэг авсан байна. Харин төсөлд хамрагдсанаар 31% нь байнгын ажил, орлоготой болсон, 25% нь усалгааны төхөөрөмжтэй болсон, 25% нь тариалангийн талбай нэмэгдсэн, 19% нь нэг га талбайгаас авах ургац нэмэгдсэн гэжээ. Үүнээс үзвэл төсөл, хөтөлбөр хэрэглэгчдэд тодорхой хэмжээгээр үр ашгаа өгсөн байна.

- Чацаргана хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэлтэй иргэдийн 27% нь төсөлд хамрагдсан бол тэдгээрийн 73% нь суулгац авсан, 12% нь зээл авсан, 10% нь сургалтад хамрагдсан, харин үлдсэн 5% нь үр бордооны дэмжлэг авсан байна.

• Төсөлд хамрагдсан Сэлэнгэ, Орхон, Улаанбаатар хотын хэрэглэгчдийн 29% нь техник, технологи сайжирсан, 26% нь байнгын ажил, орлоготой болсон, 22% нь тариалангйн талбай нэмэгдсэн, 13 % нь нэг га талбайгаас авах ургац нэмэгдсэн зэрэг эерэг ахиц өөрчлөлтийг дурьдаад хөтөлбөрийн үр дүнг дунджаар 4.45 оноогоор үнэлсэн байна.

• Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд судалгаанд хамрагдагчдын 8% нь зээлд хамрагдсан, зээлд хамрагдсан иргэд хөтөлбөрийн үр дүнг дунджаар 4.00 оноогоор үнэлсэн бөгөөд газар тариалан түлхүү эрхэлдэг Сэлэнгэ аймгийн хэрэглэгчид 4.50 гэсэн үнэлгээ өгснөөс үзвэл энэ хөтөлбөрийн хэрэгжилтэд сэтгэл ханамжтай байгааг харуулж байна.

• Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүд тодорхой хэсэгт хэрэгждэг учраас судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь олон улсыг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлбэл хамрагдах хүсэлтэй, мэдээллийг аль болох олон сувгаар түгээх, мэдээлэл авахсонирхолтой байгаагаа илэрхийлсэн байна.

3. Хүнсний салбарт

Хүнсний салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Архангай, Орхон, Сэлэнгэ аймгууд болон Улаанбаатар хотын 3 дүүргийг хамруулан нийт 680 иргэнийг түүвэр судалгаанд хамруулсан. Ингэхдээ Улаанбаатар хотод түүврийн ихэнх хувийг тархаасан бөгөөд нийт судалгаанд хамрагдагчдын 69% нь Улаанбаатар хотын хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид байна.

Хүнсний салбарын бодлогын хэрэгжилтийг үнэлэх судалгаанд тус салбарын үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрлэлийн төрлөөр харьцангуй жигд хуваарилагдан хамрагдсан байна.

• Хүнсний аюулгүй байдал хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 14% нь бүрэн мэдээлэлтэй, 38% нь ерөнхийдөө мэднэ, 21% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 27% нь огт мэдээлэлгүй байна.

• “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй эсэхийг үйлдвэрлэлийн төрлөөр харвал сүү, сүүн бүтээгдэхүүн эрхлэгчдийн 13.2% нь, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдийн 18.9% нь бүрэн мэдээлэлтэй байна.

• Тус хөтөлбөрийн хүрээнд судалгаанд хамрагдагчдын 5% нь сургалт, тоног төхөөрөмж, зээл хэлбэрээр дэмжлэг авсан байна.

• Судалгаанд хамрагдагчид хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 4.24 гэж үнэлжээ. Судалгааны явцад хэрэглэгчдийн саналыг хуваалцахад дийлэнх хэсэг нь дараах санал, бодлоо илэрхийлж байлаа. Саналыг хураангуйлан харуулбал,

- Баталгаат хүнс үйлдвэрлэж, шошго найдваржуулах,
- Бага хүүтэй зээл олгосноор тоног төхөөрөмжөө шинэчилж үйлдвэрээ өргөжүүлж, чанар сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадна.

- Бодлогын хүртээмжийн хүрээ муу цөөн тооны хүрээнд танилцуулагддаг учир шинэ бодлого яаж явагдаж байдаг нь тодорхойгүй.

- Баяр ёслолтой холбогдуулан хэн, хэзээ, хаана үйлдвэрлэсэн нь тодорхойгүй хүсний бүтээгдэхүүн их зарагддаг үүнийг төрөөс анхаарах хэрэгтэй.

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байгууллагууддаа хүрч ажилладаг байвал сайн байна.

- Бүх нийтээрээ ургамлын гаралтай хүнс хэрэглэх, ногоон хоолтны тогтсон хөтөлбөр боловсруулж, ирээдүйн хүн төрөлхтөний урт наслалт, улс орны хөгжил дэвшилд анхаарах.

- Сүүний салбарын үйлдвэрүүдэд антибиотекийн тест хийдэг болох

- Бэлтгэн нийлүүлэгчийн хяналт сул учир хүнсний аюулгүй байдал алдагдаж байна.

- Боловсруулах үйлдвэрийн хувьд сайн боловч түүхий эд, мах, сүүний чиглэлд систем алдагдсан.

- Генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнийг шинжилдэг лаборатортой болох.

- Дотооддоо үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг гаднаас импортлохоодоо хязгаарлалт хийж жижиг, дунд үйлдвэрээ дэмжих

- Жижиглэн худалдаа хийдэг иргэдэд хяналт сайн тавьдаг байх, аж ахуйн нэгжээ сайн шалгадаг хэрнээ хувь хүмүүсийн гар дээрээс зардаг шошгогүй, жингийн баталгаагүй бүтээгдэхүүн дээр хяналт тавих.

- Төсөл, хөтөлбөрийн талаарх сурталчилгаа, мэдээллийн ил тод нэн чухал зэрэг саналууд голлож байлаа.

4. Хөнгөн үйлдвэрийн салбарт

Хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Архангай, Орхон, Сэлэнгэ аймгууд болон Улаанбаатар хотын 3 дүүргийг хамруулан нийт 607 иргэнийг түүвэр судалгаанд хамруулан авсан. Ингэхдээ Улаанбаатар хотод түүврийн ихэнх хувийг тархаасан бөгөөд нийт судалгаанд хамрагдагчдын 84% нь Улаанбаатар хотын хөнгөн үйлдвэр эрхлэгчид байна.

- Хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, хөтөлбөрийн дундаж үнэлгээ 4.39 байна. Салбарын дундаж үнэлгээнд мэдээллийн хүртээмжтэй байдал шууд холбоотой гэж үзэж байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн мэдээллийн хүртээмжийн үзвэл:

- Судалгаанд хамрагдагчид хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн радио, телевиз (34%)-ээс авч байна. Түүнчлэн баг, хорооны удирдлагуудаас мэдээлэл (20%) авдаг нь харагдаж байна. Харин интернетээс мэдээлэл авах нь бага буюу судалгаанд хамрагдагчдын 3% нь байна.

- Аймгуудын нэгдсэн захыг эрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв болгох бодлогын хэрэгжилтийн явцын талаар орон нутгаас судалгаанд хамрагдагчдын 4% нь бүрэн мэдээлэлтэй, харин 38% нь огт мэдээлэлгүй байна.

- Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 5% нь бүрэн мэдээлэлтэй, 27% нь ерөнхийдөө мэднэ, 38% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 30% нь огт мэдээлэлгүй байна.

- Хоршоог хөгжүүлэх хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 4% нь бүрэн мэдээлэлтэй, 21% нь ерөнхийдөө мэднэ, 36% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 39% нь огт мэдээлэлгүй байна.

- Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөрийн талаар судалгаанд хамрагдагчдын 2% нь бүрэн мэдээлэлтэй, 20% нь ерөнхийдөө мэднэ, 31% нь сонсож байсан, гэхдээ бүрэн мэдээлэлгүй, харин 47% нь огт мэдээлэлгүй байна.

ЗӨВЛӨМЖ

ХХААХҮ-ийн салбарын хэрэглэгчийн үнэлгээ 2016 судалгааны үр дүн, дүгнэлтэд үндэслэн судалгааны багаас дараах зөвлөмж өгч байна. Үүнд:

1. МАА-н салбарт

Судалгаанд хамрагдагчид МАА-н салбарт хэрэгжүүлж буй бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг **4.18** гэж үнэлсэн байна.

- Судалгаанд хамрагдагчдын 22% нь интернет, зарлалын самбар, зурагт хуудас зэргээр дамжуулан түгээж буй ХХААХҮ-ийн салбарын бодлого, төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэлд төдийлөн анхаарал хандуулдаггүй байна. Иймд МАА-н салбарт хэрэгжиж буй бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг интернет, зарлалын самбар, зурагт хуудсаар дамжуулан түгээхдээ хэрэглэгчдийн сонирхолд нийцсэн, ойлгоход хялбар, дүрслэлээр илэрхийлж илүү үр дүнтэй, хүртээмжтэй болгох;

- Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, түүний хэрэгжилтийг малчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор тэдний санал, тэдний туршлагыг судлах, хэлэлцүүлэг хийх, бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжлилгээний бүхий л үе шатанд малчдын оролцоог хангах;

- Судалгаанд хамрагдагчид ХАА-н биржийн үйл ажиллагааг дунджаар 4.23 оноогоор үнэлсэн байгаа хэдий ч биржийн үйл ажиллагааг эрэлт, хэрэгцээнд илүү суурилсан үйлчилгээнд хөрвүүлэх, шинэ үйлчилгээ бий болгох;

- Харин олон улсын төсөл, хөтөлбөрийн талаар энэ удаагийн судалгаанд хамрагдагчид мэдээлэл бага (3.76) –тай байсан бөгөөд олон улсын төсөл, хөтөлбөрүүд, хэрэгжилтийн талаарх мэдээллийг аль болох олон сувгаар иргэдэд түгээж мэдээлэл хүргэх нь илүү оновчтой.

2. Газар тариалангийн салбарт

Судалгаанд хамрагдагчид газар тариалангийн салбарт хэрэгжиж буй бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг **4.39** гэж үнэлжээ.

- Мэдээлэл хүргэх сувгаа өргөжүүлэх, зарлалын самбарын мэдээллийг тухай бүр шинэчлэх, зурагт хуудсыг хэрэглэгчдэд ойлгомжтой хэлбэрээр бэлтгэн мэдээлэл түгээх;

○ Судалгаанд хамрагдагчид хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх бодлогын талаар харьцангуй сул мэдээлэлтэй байгаа тул зорилтот бүлэгт чиглэсэн зорилтот мэдээллийг цаг тухайд нь мэдээллийн олон сувгаар хүргэх;

○ Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлогын талаар хамрагдагчдын талаар мэдээлэлтэй хэрэглэгчдийн 14% нь төсөлд хамрагдсан бөгөөд төслийн үр дүнг дунджаар 4.60 гэж үнэлсэн байна. Үүнээс үзвэл тодорхой хэмжээгээр үр ашгаа өгч байгаа хөтөлбөрүүдийг тогтмолжуулах, хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатай;

○ Судалгаанд хамрагдагчдын ихэнх нь олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүд аймаг, орон нутагт нь хэрэгжүүлбэл хамрагдах хүсэлтэй байгаа боловч мэдээллийг олон сувгаар тогтмол давтамжтайгаар түгээж байх,

○ Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байршилд хэрэгжүүлэх, мэдээллийг нэг удаа бус тогтмол хэлбэрээр түгээж байх;

3. Хүнсний салбарт

Судалгаанд хамрагдагчид хүнсний салбарын бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг 4.24 гэж үнэлжээ.

○ Судалгааны явцад хэрэглэгчдийн саналаас үзвэл ялангуяа цаашид баталгаат хүнс үйлдвэрлэж, шошго найдваржуулах, бага хүүтэй зээл олгосноор тоног төхөөрөмжөө шинэчилж үйлдвэрээ өргөжүүлж чанар сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бодлого боловсруулах, хэрэгжүүлэлтэд хяналт тавих явцад иргэдийн оролцоо хангалтгүй, ургамлын гаралтай хүнс хэрэглэх бодлоготой байх, генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнийг шинжилдэг лабораторитой болох, жижиглэн худалдаа хийдэг иргэдэд хяналт сайн тавьдаг байх, аж ахуйн нэгжээ сайн шалгадаг хэрнээ хувь хүмүүсийн гар дээрээс зардаг шошгогүй, жингийн баталгаагүй бүтээгдэхүүн дээр хяналт тавих бодлоготой болох, төсөл, хөтөлбөрийн талаарх сурталчилгаа, мэдээллийг тогтмолжуулах, ил тод болгох шаардлагатай;

5. Хөнгөн үйлдвэрийн салбарт

Судалгаанд хамрагдагчид хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг 4.39 гэж үнэлжээ.

○ Салбарын дундаж үнэлгээнд мэдээллийн хүртээмжтэй байдал шууд холбоотой байгаа судалгааны үр дүнгээс харагдаж байгаа тул мэдээллийн хүртээмжийг сайжруулах;

○ Хэрэглэгчдэд эерэг үр дүн нь тодорхой хэмжээгээр мэдэгдэж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх, тухайлбал, судалгаанд хамрагдсан хэрэглэгчдээс нилээд өндөр үнэлгээ өгсөн Монгол улсыг үйлдвэржүүлэх болон Хоршоог хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хэрэглэгчдэд мэдээлэх, хөтөлбөрт хамрагдаж үр дүнг нь хүртсэн хэрэглэгчдийн “сайн туршлага”-ыг сургалт, хэлэлцүүлэг хийх

ХХААХҮ-ийн хэрэглэгчийн үнэлгээ 2016 судалгааны явцад хэрэглэгчдээс урьдчилан бэлтгэсэн асуулгын зэрэгцээ нээлттэй асуулгаар санал авсан.